

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН 2018 ОНЫ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ .....	2
2. Аудитын тайлан .....	4
2.1 Оршил.....	4
2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	5
2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	7
2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	7
2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	8
2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	10
2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	10
2.11 Шилэн дансны мэдээлэл .....	11
2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	11
2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
3. Менежментийн захидал.....	12
4. Аудитлагдсан санхүүгийн тайлан.....	14
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	14
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	15
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	17
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	19
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	20
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	22

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

НАЛАЙХ ДАХЬ МЭРГЭЖИЛ СУРГАЛТ  
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВИЙН ЗАХИРАЛ  
Ц.СОНГУУЛЬ ТАНАА

2019.02.25 № 06/255  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу “Налайх дахь мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв”-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

“Налайх дахь мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв”-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Налайх дахь мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв”-ийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2. Аудитын тайлан**

### **2.1 Оршил**

Налайх дахь Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Налайх дахь Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн захирал Ц.Сонгууль танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### **2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Налайх дахь Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Налайх дахь Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 09 дүгээр сарын 20-ноос 2019 оны 02 дугаар сарын 16-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 18-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, “Ихмонгол хөлөг Аудит” ХХК хэрэгжүүлэв.

Налайх дахь Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Ихмонгол хөлөг Аудит” ХХК-д 2019 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 29 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Налайх дахь Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Налайх дахь Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв нь Нийгмийн түншлэл, ажил олгогчдын оролцоог нэмэгдүүлж, хувь хүний чадамжинд суурилсан, мэдээллийн технологид тулгуурласан, ирээдүйг угтсан, насан туршийн боловсрол олгох сургалтын тогтолцоог бий болгож, сургалтын орчныг сайжруулан, багшлах боловсон хүчний чадавхийг дээшлүүлж, төлөвшсөн, чадварлаг мэргэжилтэй ажилтан бэлтгэхэд оршино. гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдтай байгуулсан үр дүнгийн гэрээгээр Налайх дахь Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Нийгмийн түншлэл ажил олгогчдын оролцоог нэмэгдүүлэх;
- Төгсөгчдийг ажлын байраар хангах;
- Сургалтын орчинг сайжруулах;
- Багшлах боловсон хүчний чадавхийг үе шаттайгаар дээшлүүлэх;
- Гадаад харилцаагаа өргөжүүлж төсөл хөтөлбөрүүдэд хамрагдах гэсэн арга замыг хэрэгжүүлж ажиллах;

Налайх дахь Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Налайх дахь Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа эрх зүйн орчны томоохон шинэчлэлт, өөрчлөлт ороогүй байна.

## **2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Налайх дахь Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Налайх дахь Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous 3.0” програм хангамж ашигладаг байна.

Налайх дахь Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөтэй гэж үзлээ.

## **2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Налайх дахь Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 14 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 14 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн 1 хувиар сонгов.

Үр дүнгийн тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь нийт хөрөнгө, цэвэр хөрөнгө, нийт орлогын дүнгээс тооцоход өндөр байгаатай холбоотой юм.

Налайх дахь Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал нь 1,533,170.4 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 15,331.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь материаллаг алдаа илүү давах магадлал бага гэж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## **2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 14 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 4 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 5 асуудлыг алдаа, зөрчилд

тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 5 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

/мянган төгрөг/

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	9,367.8	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	1,312.6	
3	Албан шаардлага өгсөн	1	585.5	
	Дүн	5	11,265.9	

### 2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Нийт 26 иргэнээс 14,103.8 төгрөгийн худалдан авалт хийхдээ 1,312.5 мянган төгрөгийн ХХОАТ-ыг суутгаагүй, тайлагнаж төлөөгүй байна. Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.1 -д" энэ хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т заасан орлогын дүнд 23.2.4-т заасан хувиар тус тус албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: 26 иргэнээс суутгаагүй, тайлагнаж төлөөгүй нийт 1,312.5 мянган төгрөгийг төлүүлэх төлбөрийн акт тогтоох тухай үйлчлүүлэгчид мэдэгдсэн ба үйлчлүүлэгч хүлээн зөвшөөрсөн.

Иргэн Б.Одхүү 198.0 мянган төгрөг, Н.Болормаа 852.9 мянган төгрөгийн нийт 1,050.9 мянган төгрөгийн бараа материалын Е баримтын регистрийн дугаар нь төлбөрийг шилжүүлсэн төлбөрийн хүсэлтийн регистрийн дугаартай таарахгүй байгаа тул татвар төлөгчийн баримт гэж үзэх үндэслэлгүй байгаа тул ХАОАТ 111.0 мянган төгрөгийг суутган татварт тайлагнаагүй байна.

Өмнөх аудитаар Засгийн газрын 2012 оны 106 дугаар тогтоолоор баталсан нэг хүүхдийн хоногийн хоолны зардлын лимитийг мөрдөөгүйгээс хоолны зардлыг 3,759.9

мянган төгрөгөөр хэтрүүлснийг бууруулсан боловч хоолны зардлыг тайлант онд 585.5 төгрөгөөр хэтрүүлсэн байна.

Шийдвэрлэсэн: Албан шаарлага өгөх

Энэ нь үнэн зөв байдал, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Хувь Хүний Орлогын албан татварын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.1 -д" энэ хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т заасан орлогын дүнд 23.2.4-т заасан хувиар тус тус албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Аудитын явцад холбогдох анхан шатны баримтыг бүрдүүлж шалгуулсан болно.

Бараа материалыг орлого авахдаа 40,607.0 мянган төгрөгийн бэлтгэн нийлүүлэгчийн зарлагын падаантай боловч НӨАТ-ын падаангүй орлого авсан байна.

Энэ нь үнэн зөв байдал, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна НӨАТ-ын тухай хуулийн 4.1.3."нэгдсэн дугаар бүхий нэмэгдсэн өртгийн албан татварын падаан" гэж борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ, тэдгээрийн нэгжийн болон нийт үнэ, түүнчлэн нэмэгдсэн өртгийн албан татварын хэмжээг тусгасан, татварын албанаас олгосон нэгдсэн дугаар бүхий нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт бичгийг; хэлнэ гэсэн заалтыг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Аудитын явцад нэмэгдсэн өртгийн албан татварын баримтыг бүрдүүлж шалгуулсан.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны "Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай" 253 дугаар тогтоолоор шилжиж ирсэн 29,543.0 мянган төгрөгийн анхын өртөгтэй, 14,443.5 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, 15,100.0 мянган төгрөгийн үлдэгдэл өртөгтэй Тоёота Ланд круйзер-80 автомашиныг 2018 оны 7 дугаар сарын 25-ны өдөр нягтлан бодох бүртгэлд бүртгэхдээ 14,443.5 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдлийг бүртгээгүй байна.

Энэ нь иж бүрэн байдал, үнэн зөв байдал, эрх ба үүрэг, тайлагнал ба тодруулга батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолын хавсралт "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.2-т "Төрийн өмчит хуулийн этгээд нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрт зааснаар хөрөнгө хүлээлцэх ажлыг зохион байгуулж, баланс тайланд хөдлөл өөрчлөлтийг тусгана." гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Санхүүгийн тайланд 14,443.5 мянган төгрөгийн элэгдлийг залруулж бүртгэсэн.

Аудитын тулган баталгаажуулах захидлаар Налайх Дулааны станц ТӨХК-д төлөх 1,260.6 мянган төгрөгийн өр төлбөрийг санхүүгийн тайланд тусгаагүй байна.

Энэ нь үнэн зөв байдал, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасныг мөрдөж ажиллах гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Санхүүгийн тайланд 1,260.6 мянган төгрөгийн өр төлбөрийг нэмж бүртгэсэн.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг 8,139.9 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.

Энэ нь тайлагнал ба тодруулга, үнэн зөв байдал батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6 зүйлийн 6.3.1 д заасан "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, илэрхийлэн бүртгэж, тайлагнах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Төсвийн гүйцэтгэлийн тайланд залруулж тайлагнасан.

## **2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ**

Дараагийн аудитаар Засгийн газрын 2012 оны 106 дугаар тогтоолоор баталсан "Хүүхдийн хоолны норматив, тооцоо болон Эрчим хүчний зохицуулах зөвлөлөөс баталсан халаалтын үнэ тарифын дагуу төсвийн төслийг батлуулсан эсэхийг дараагийн аудитаар дахин үзэх шаардлагатай гэж үзсэн.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй байна.

## **2.10 ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Налайх дахь Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 1,403,190.3 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 1,395,974.0 мянган төгрөг буюу 99.5 хувьтай байгаа нь Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргаж төсвийн хэмнэлт үүсгэн ажилласнаас шалтгаалжээ.

## **2.11 Шилэн дансны мэдээлэл**

Налайх дахь Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

## **2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 92.0 хувьтай байна.

Өмнөх аудитаар Засгийн газрын 2012 оны 106 дугаар тогтоолоор баталсан нэг хүүхдийн хоногийн хоолны зардлын лимитийг мөрдөөгүйгээс хоолны зардлыг 3,759,946.35 төгрөгөөр хэтрүүлснийг бууруулсан боловч хоолны зардлыг тайлант онд 585,542.51 төгрөгөөр хэтрүүлсэн байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

## **2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Налайх дахь Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Налайх дахь Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### 3. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Налайх дахь Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### 1. Авлага, өглөгийн талаар

##### 1.1 Илрүүлэлт:

Аудитын тулган баталгаажуулах захидлаар Налайх Дулааны станц ТӨХК-д төлөх 1,260.6 мянган төгрөгийн өр төлбөрийг санхүүгийн тайланд тусгаагүй, Авлага, өр төлбөр оны эхнээс нэмэгдэж 8,124.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Энэ нь үнэн зөв байдал, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэх заалтыг хэрэгжүүлж ажиллах" гэх заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

##### 1.2 Эрсдэл:

Авлага, өглөгийг нягтлан бодох бүртгэлд тусгахгүй орхигдуулах.

##### 1.3 Өгсөн зөвлөмж:

Авлага, өглөгийн тооцоо нийлж, өр авлагыг нэмэгдүүлэхгүй ажиллах.

##### 1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитын байгууллагаас ирүүлсэн асуудлын бүртгэлээр баталгаажуулсан ажлуудыг хийж гүйцэтгэнэ.

## 2. Зардлын талаар

### 2.1 Илрүүлэлт:

Эрчим хүчний зохицуулах зөвлөлөөс баталсан халаалтын үнэ тарифын дагуу төсвийн төлөвлөлтийг хийдэггүйгээс сар бүр халаалтын өр төлбөр үүсгэж, жилийн эцэст хэмнэлтээс тодотгож байна. Халаалтын зардлыг 7,218.8 мянган төгрөгөөр хэтрүүлснийг гэрэл цахилгааны зардлаас шилжүүлэн тооцсон байна. Энэ нь үнэн зөв байдал, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэх заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

### 2.2 Эрсдэл:

Зардлыг зөв зохистой төлөвлөхгүй байх.

### 2.3 Өгсөн зөвлөмж:

Зардлыг зөв зохистой төлөвлөж ажиллах.

### 2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитын байгууллагаас ирүүлсэн асуудлын бүртгэлээр баталгаажуулсан ажлуудыг хийж гүйцэтгэнэ.

## 3. Зардлын талаар

### 3.1 Илрүүлэлт:

Налайх МСҮТ-ийн нийт ахмадуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээнд зарцуулсан 978.0 мянган төгрөгийг хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан ажиллагсдад олгох 5 жилийн тэтгэмжийн зардлаас санхүүжүүлсэн байна. Энэ нь үнэн зөв байдал, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэх заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

### 3.2 Эрсдэл:

Зардлыг зөв зохистой төлөвлөхгүй байх.

### 3.3 Өгсөн зөвлөмж:

Зардлыг зөв зохистой төлөвлөж ажиллах.

### 3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитын байгууллагаас ирүүлсэн асуудлын бүртгэлээр баталгаажуулсан ажлуудыг хийж гүйцэтгэнэ.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Аудитлагдсан санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл /төгрөгөөр/
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	193,533,037.09	203,168,511.76
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
33	АВЛАГА	2,398,458.07	6,852,458.25
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,398,458.07	2,059,684.00
335	Бусад авлага	-	4,792,774.25
3351	Байгууллагаас авах авлага	-	4,792,774.25
35	БАРАА МАТЕРИАЛ	191,134,579.02	196,316,053.51
354	Хангамжийн материал	191,134,579.02	196,316,053.51
35410	Бичиг хэргийн материал	20,363,860.00	10,799,610.00
35420	Аж ахуйн материал	53,567,004.60	52,739,957.60
35440	Түлш, шатах тослох материал	-	210,000.00
35460	Хүнсний материал	3,754,644.01	4,134,449.50
35470	Бусад хангамжийн материал	113,449,070.41	128,432,036.41
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,981,059,440.37	8,547,185,000.67
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,981,059,440.37	8,547,185,000.67
392	Биет хөрөнгө	1,981,059,440.37	7,893,654,589.59
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,324,109,407.00	7,689,952,576.59
39202	Хуримтлагдсан элэгдэл	-3,599,319,197.30	-
39203	Авто-тээврийн хэрэгсэл	92,500,000.00	150,517,320.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-70,941,666.31	-128,846,617.95
39205	Машин тоног төхөөрөмж -компьютер	1,450,900,494.76	1,454,587,144.76
39206	Хуримтлагдсан элэгдэл	-1,410,710,817.12	-1,425,219,682.19
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	385,916,397.02	386,096,397.02
39208	Хуримтлагдсан элэгдэл	-213,274,771.68	-257,403,442.64
39217	Ном	21,879,594.00	23,970,894.00
393	Биет бус хөрөнгө	-	653,530,411.08
39303	Бусад биет бус хөрөнгө	19,390,558.00	673,134,858.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-19,390,558.00	-19,604,446.92
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,174,592,477.46	8,750,353,512.43
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	1,271,985.78
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	1,271,985.78
413	Өглөг	-	1,271,985.78
4136	Бусад өглөг	-	1,271,985.78
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,174,592,477.46	8,749,081,526.65
51	Засгийн газрын хувь оролцоо	2,174,592,477.46	8,749,081,526.65
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,693,760,852.09	2,346,405,152.09
51101	Өмч: - төрийн	1,693,760,852.09	2,346,405,152.09
512	Хуримтлагдсан үр дүн	-1,420,674,681.27	-1,458,987,641.15
51210	Өмнөх үеийн үр дүн	-1,420,674,681.27	-1,420,674,681.27
51220	Тайлант үеийн үр дүн	-	-38,312,959.88
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,901,506,306.64	7,861,664,015.71
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,174,592,477.46	8,750,353,512.43

#### 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН -I	1,091,432,284.00	1,494,857,448.33
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	55,090,501.00	101,577,148.33
120	Нийтлэг татварын бус орлого	55,090,501.00	101,577,148.33
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	50,913,250.00	101,284,374.08
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,750,250.00	10,923,650.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	47,163,000.00	90,360,724.08
120009	Бусад орлого	4,177,251.00	292,774.25
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,036,341,783.00	1,393,280,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,031,939,100.00	1,393,280,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,031,939,100.00	1,393,190,300.00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	-	90,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	4,402,683.00	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	4,402,683.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,335,121,997.43	1,533,170,408.21
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,335,121,997.43	1,533,170,408.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,253,632,725.43	1,481,717,101.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	540,014,943.00	771,507,374.07
210101	Үндсэн цалин	474,285,583.00	610,255,789.07
210102	Нэмэгдэл	33,700,800.00	109,627,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	32,028,560.00	51,624,585.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	68,401,023.78	91,484,200.00
210201	Тэтгэврийн даатгал	46,348,153.00	60,989,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,662,670.78	7,623,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,570,500.00	6,098,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	892,800.00	1,524,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,926,900.00	15,247,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	127,925,239.00	286,961,885.78
210301	Гэрэл, цахилгаан	11,817,562.00	20,087,099.20
210302	Түлш, халаалт	103,749,272.00	241,565,906.58
210303	Цэвэр, бохир ус	12,358,405.00	25,308,880.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,242,319.00	32,354,372.00
210401	Бичиг хэрэг	15,097,519.00	18,203,520.00
210402	Тээвэр, шатахуун	3,269,000.00	4,296,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,191,300.00	8,882,852.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	648,000.00	972,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	36,500.00	-
2105	Нормативт зардал	22,003,019.67	28,167,782.51
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	483,900.00	783,800.00
210502	Хоол, хүнс	21,519,119.67	27,383,982.51
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	33,722,884.20	38,710,517.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	98,350.00	8,000.00

Налайх дахь мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210604	Урсгал засвар	33,624,534.20	38,702,517.00
2107	Томилолт, зочны зардал	1,308,600.00	1,746,100.00
210702	Дотоод албан томилолт	1,308,600.00	1,746,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,165,708.00	35,580,168.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	22,476,360.00	31,908,720.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,430,000.00	2,087,600.00
210803	Даатгалын үйлчилгээ	895,348.00	784,140.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	265,000.00	250,708.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	99,000.00	99,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	450,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	409,848,988.78	195,204,701.85
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	37,057,001.60	52,077,579.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	372,791,987.18	143,127,122.85
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	81,489,272.00	51,453,307.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	81,489,272.00	43,313,418.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	90,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	63,870,072.00	5,346,218.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	17,619,200.00	37,877,200.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	8,139,889.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	8,139,889.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН -3=-1--2	-243,689,713.43	-38,312,959.88
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН -4=-145-225	-	-
5	НИЙТ ҮР ДҮН -5=-3+-4	-243689,713.43	-38,312,959.88

### 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН -1	1,035,689,350.00	1,404,203,950.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,750,250.00	10,923,650.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,750,250.00	10,923,650.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,750,250.00	10,923,650.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,750,250.00	10,923,650.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,031,939,100.00	1,393,280,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,031,939,100.00	1,393,280,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,031,939,100.00	1,393,190,300.00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	-	90,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН -2	962,579,487.00	1,398,114,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	962,579,487.00	1,398,114,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	881,090,215.00	1,346,660,693.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	545,418,619.00	771,168,600.00
210101	Үндсэн цалин	479,689,259.00	609,814,100.00
210102	Нэмэгдэл	33,700,800.00	109,627,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	32,028,560.00	51,727,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	61,164,076.00	91,484,200.00
210201	Тэтгэврийн даатгал	43,247,676.00	60,989,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,526,200.00	7,623,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,570,500.00	6,098,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	892,800.00	1,524,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,926,900.00	15,247,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	127,925,239.00	285,697,900.00
210301	Гэрэл, цахилгаан	11,817,562.00	20,083,766.00
210302	Түлш, халаалт	103,749,272.00	240,305,254.00
210303	Цэвэр, бохир ус	12,358,405.00	25,308,880.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,125,000.00	19,597,812.00
210401	Бичиг хэрэг	4,294,400.00	2,878,060.00
210402	Тээвэр, шатахуун	3,269,000.00	4,203,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,712,300.00	8,930,852.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	648,000.00	972,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,201,300.00	2,613,900.00
2105	Нормативт зардал	18,742,201.00	33,667,088.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	275,000.00	783,800.00
210502	Хоол, хүнс	13,290,701.00	27,755,788.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,176,500.00	5,127,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,327,150.00	31,666,745.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	437,550.00	1,781,675.00
210604	Урсгал засвар	14,889,600.00	29,885,070.00
2107	Томилолт, зочны зардал	1,308,600.00	1,746,100.00
210702	Дотоод албан томилолт	1,308,600.00	1,746,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	28,265,108.00	36,201,498.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	23,636,760.00	30,713,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,518,000.00	3,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,965,348.00	784,140.00

Налайх дахь мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210804	Тээврийн хэрэгслийн татвар	409,700.00	250,708.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	99,000.00	99,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	636,300.00	854,250.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	62,814,222.00	75,430,750.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	62,814,222.00	75,430,750.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	81,489,272.00	51,453,307.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	81,489,272.00	43,313,418.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	90,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	63,870,072.00	5,346,218.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	17,619,200.00	37,877,200.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	8,139,889.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	8,139,889.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ -3=-1--2	<u>73,109,863.00</u>	<u>6,089,950.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН -4	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН -5	1,972,760.00	6,089,950.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,972,760.00	6,089,950.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,972,760.00	6,089,950.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,972,760.00	6,089,950.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ -6=-4--5	<u>-1,972,760.00</u>	<u>-6,089,950.00</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	-
24	ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР	-	-
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	-	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ -8=-3+-6+-7	71,137,103.00	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	404.00	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	71,137,507.00	-

#### 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
<b>2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	1,693,760,852.09	1,901,810,760.44	-956,209,871.46	2,639,361,741.07
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	1,693,760,852.09	1,901,810,760.44	-956,209,871.46	2,639,361,741.07
Тайлант үеийн үр дүн	-	-	-243,689,713.43	-243,689,713.43
<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	1,693,760,852.09	1,901,506,306.64	-1,420,674,681.27	2,174,592,477.46
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	1,693,760,852.09	1,901,506,306.64	-1,420,674,681.27	2,174,592,477.46
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	5,960,157,709.07	-	5,960,157,709.07
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	652,644,300.00	-	-	652,644,300.00
Тайлант үеийн үр дүн	-	-	-38,312,959.88	-38,312,959.88
<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	2,346,405,152.09	7,861,664,015.71	-1,458,987,641.15	8,749,081,526.65

#### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,403,190,300.00	1,395,974,061.00	-7,216,239.00	99.5
УРСГАЛ ЗАРДАЛ	1,403,190,300.00	1,395,974,061.00	-7,216,239.00	99.5
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,359,887,100.00	1,352,750,643.00	-7,136,457.00	99.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	771,168,600.00	771,168,600.00	-	100.0
Үндсэн цалин	609,814,100.00	609,814,100.00	-	100.0
Нэмэгдэл	109,627,000.00	109,627,000.00	-	100.0
Унаа хоолны хөнгөлөлт	51,727,500.00	51,727,500.00	-	100.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	91,484,200.00	91,484,200.00	-	100.0
Тэтгэврийн даатгал	60,989,500.00	60,989,500.00	-	100.0
Тэтгэмжийн даатгал	7,623,600.00	7,623,600.00	-	100.0
ҮОМШӨ-ний даатгал	6,098,900.00	6,098,900.00	-	100.0
Ажилгүйдлийн даатгал	1,524,800.00	1,524,800.00	-	100.0
Эрүүл мэндийн даатгал	15,247,400.00	15,247,400.00	-	100.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	285,697,900.00	285,697,900.00	-	100.0
Гэрэл, цахилгаан	26,422,700.00	20,083,766.00	-6,338,934.00	76.0
Түлш, халаалт	233,086,400.00	240,305,254.00	7,218,854.00	103.1
Цэвэр, бохир ус	26,188,800.00	25,308,880.00	-879,920.00	96.6
Хангамж, бараа материалын зардал	19,737,200.00	19,597,812.00	-139,388.00	99.3
Бичиг хэрэг	2,945,200.00	2,878,060.00	-67,140.00	97.7
Тээвэр, шатахуун	4,207,500.00	4,203,000.00	-4,500.00	99.9
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,931,800.00	8,930,852.00	-948.00	100.0
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,038,000.00	972,000.00	-66,000.00	93.6
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,614,700.00	2,613,900.00	-800.00	100.0
Нормативт зардал	38,413,700.00	33,667,088.00	-4,746,612.00	87.6
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	783,900.00	783,800.00	-100.00	100.0
Хоол, хүнс	32,481,800.00	27,755,788.00	-4,726,012.00	85.5
Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,148,000.00	5,127,500.00	-20,500.00	99.6
Эд хогшил, урсгал засварын зардал	31,671,600.00	31,666,745.00	-4,855.00	100.0
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,782,000.00	1,781,675.00	-325.00	100.0
Урсгал засвар	29,889,600.00	29,885,070.00	-4,530.00	100.0
Томилолт, зочны зардал	2,524,500.00	1,746,100.00	-778,400.00	69.2
Дотоод албан томилолт	2,524,500.00	1,746,100.00	-778,400.00	69.2
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	37,668,700.00	36,201,498.00	-1,467,202.00	96.1

Налайх дахь мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	31,541,400.00	30,713,400.00	-828,000.00	97.4
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,500,000.00	3,500,000.00	-	100.0
Даатгалын үйлчилгээ	880,000.00	784,140.00	-95,860.00	89.1
Тээврийн хэрэгслийн татвар	658,300.00	250,708.00	-407,592.00	38.1
Тээврийн хэрэгслийн оношлогоо	99,000.00	99,000.00	-	100.0
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	990,000.00	854,250.00	-135,750.00	86.3
Бараа үйлчилгээний бусад зардал	81,520,700.00	81,520,700.00	-	100.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	81,520,700.00	81,520,700.00	-	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	43,303,200.00	43,223,418.00	-79,782.00	99.8
Бусад урсгал шилжүүлэг	43,303,200.00	43,223,418.00	-79,782.00	99.8
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	5,426,000.00	5,346,218.00	-79,782.00	98.5
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	37,877,200.00	37,877,200.00	-	100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,403,190,300.00	1,395,974,061.00	-7,216,239.00	99.5
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,393,190,300.00	1,385,050,411.00	-8,139,889.00	99.4
Улсын төсвөөс санхүүжих	1,393,190,300.00	1,385,050,411.00	-8,139,889.00	99.4
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	10,000,000.00	10,923,650.00	923,650.00	109.2
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,000,000.00	10,923,650.00	923,650.00	109.2
АЖИЛЛАГСАДЫН ТОО	91.00	89.00	-2.00	97.8
Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	48.00	46.00	-2.00	95.8
Үйлчлэх ажилтан	42.00	42.00	-	100.0

**5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

Огноо:	<b>2019.02.25</b>	Аудитын нэр:	<b>2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан</b>	Аудитын код:
				<b>САГ-2019/71/СТА-ТШЗ</b>

Шалгагдсан байгууллагын нэр:	<b>Налайх дахь мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв</b>	Мянган төгрөгөөр
------------------------------	---	------------------

Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
		Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5
Нийт 26 иргэнээс 14,103,860.00 төгрөгийн худалдан авалт хийхдээ 1,312,586.00 төгрөгийн ХХОАТ-ыг суутгаагүй, тайлагнаж төлөөгүй байна.	1,312.6	Төлбөрийн акт	Захирал	Ц.Сонгууль
Өмнөх аудитаар Засгийн газрын 2012 оны 106 дугаар тогтоолоор баталсан нэг хүүхдийн хоногийн хоолны зардлын литимтийг мөрдөөгүйгээс хоолны зардлыг 3,759,946.35 төгрөгөөр хэтрүүлснийг бууруулсан боловч хоолны зардлыг тайлант онд 585,542.51 төгрөгөөр хэтрүүлсэн байна.	585.4	Албан шаардлага	Захирал	Ц.Сонгууль
Аудитын тулган баталгаажуулах захидлаар Налайх Дулааны станц ТӨХК-д төлөх 1,260,652.58 төгрөгийн өр төлбөрийг санхүүгийн тайланд тусгаагүй байна.	1,260.7	Зөвлөмж	Захирал	Ц.Сонгууль
1. Эрчим хүчний зохицуулах зөвлөлөөс баталсан халаалтын үнэ тарифын дагуу төсвийн төлөвлөлтийг хийдэггүйгээс сар бүр халаалтын өр төлбөр үүсгэж, жилийн эцэст хэмнэлтээс тодотгож байна. Халаалтын зардлыг 7,218,854.00 төгрөгөөр хэтрүүлснийг гэрэл цахилгааны зардлаас шилжүүлэн тооцсон.	7,218.9	Зөвлөмж	Захирал	Ц.Сонгууль

